



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 сарын 20 өдөр

Дугаар A/65

Маншалговь

Г Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл 7  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалт, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: О.Бат-Эрдэнэ -Аймгийн Засаг дарга  
Дэд дарга: Ж.Мөнхчулуун - Аймгийн Засаг даргын орлогч  
Гишүүд: С.Хулан - Аймгийн ЗДТГ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргжилтэн  
А.Ганбат -Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга  
Б.Мөнхчулуун -Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга  
Б.Түвшин-Эрдэнэ-Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүлэгч  
Э.Азжаргал-Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүлэгч  
Ж.Зоригтбаатар-Аймгийн ажил олгогч эздийн холбооны дарга  
О.Саруул - Говийн бүсийн арга зүйн төвийн менежер  
Б.Ням-MYXAYT-ийн Дундговь аймаг дахь салбар танхимын дарга

Нарийн бичгийн дарга: Э.Цэвэлмаа - ХХҮГ-ын хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга

Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог ханган, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, дурмийн дагуу ажиллахыг дэд дарга /Ж.Мөнхчулуун/-д үүрэг болгосугай.

Гурав. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 4-ний өдрийн А/136 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200212